



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 19/12

Улаанбаатар хот

### Сайжруулсан түлшний үнэ, борлуулалтын урамшууллыг тогтоох тухай

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10 дах заалт, 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1.3 дэх заалт, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн "Нийслэлийн агаарын бохирдлын тухай" 03-03 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

1. Сайжруулсан хатуу түлшний үнийг түүхий нүүрсний үнээс хэтрүүлэхгүй байх, түлшний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор сайжруулсан хатуу түлшний нэг тонн тутмын үнийг 150 000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгөөр, сайжруулсан түлшний борлуулалтын нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллыг 15 000 /Арван таван мянган/ төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. 2019 онд борлуулалтын урамшуулалд олгох хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайханд даалгасугай.
3. Уг тогтоол гарсантай холбогдуулан цаашид сайжруулсан түлшний татаас, борлуулалтын урамшуулалд олгох хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, нийслэлийн төсөвт тусгаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн дэд сайд Х.Булгантуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарт тус тус даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Н.ЦЭРЭНБАТ